

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2022.03.23

Наран сум

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

Төрийн албан хаагчдын нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээг сумандаа 4 дэх жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд нийт 97 төрийн албан хаагчид хамрагдсан. Аймгийн ЗДТГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн н.Оюунтөгс урилгаар хүрэлцэн ирж, алба хаагчдад мэдээлэл хийн, тулгамдаж буй асуудлыг ярилцлаа.



Мөн үйл ажиллагааны төгсгөлд сумын Засаг даргатай төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нар гүйцэтгэлийн төлөвлөгөө үзэглэх арга хэмжээг зохион байгуулсан болно.



2022 он 03 дугаар сарын 17-ны өдөр сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран “Зөвийг зөвлөө” арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 40 гаруй иргэд хамрагдсан бөгөөд Архидан согтуурах гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, болон хүрээлэн буй орчны гэмт хэргийн зөрчлөөс сэргийлэх эрх зүйн мэдээ мэдээллийг өгч нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



Уг арга хэмжээний хүрээнд танин мэдэхүйн АХА тэмцээн болон хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулж иргэдийг урамшуулсан.



АЛБАН ХЭРЭГ



ХӨТЛӨЛТИЙН

ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны 03 дугаар сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

03-р сарын байдлаар дээд газраас 23 нийт албан бичиг ирснээс, хариутай бичиг 10 ирж, 5 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 5 албан бичиг байна.

Мөн 03 сарын байдлаар нийт 5 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 3, Аймгийн Засаг даргын Албан даалгавар -1, Аймгийн ТАЗ-ийн Тогтоол 1 ирж хэрэгжиж байна.

Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:

2022 оны 03-р сарын байдлаар;

- 1.Сумын Засаг даргын А-Захирамж - 2
- 2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 1
- 4.Засаг даргын албан бичиг -5
- 5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 0
- 6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 0

7.ЗДТГ-ын даргын албан бичиг -8


Нийт 11 албан бичгийг цахим шуудангаар болон сумын шуудангаар хүргүүлж ажилласан.

Өргөдөл гомдлын талаар:

2022 оны 03-р сарын байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 3 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэгдсэн 1, хугацаа болоогүй 2 шийдвэрлэлтийн хувь 33,3%.

Архивын ажлын талаар:


2021 оны баримт бичгүүдийг эмхлэн цэгцлэх, холбогдох албан тушаалтнуудаас татан авах ажил хийгдэж эхлээд байна.



2022 оны 03 дугаар сарын байдлаар архиваас 2 иргэн, албан тушаалтад нийт 8 хадгаламжийн нэгжийг ашиглуулж, лавлагаа хуулбарыг олгосон байна.

Erp-mongolia ажлын талаар:

2022 оны 2-р сарын 17-нд Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем – \erp-mongolia\ талаар Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад сургалт явуулсан. Уг сургалтад нийт 12 албан хаагч идэвхтэй оролцсон.



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэний бүртгэлийн үйлчилгээг иргэний хүсэлтийн дагуу тасралтгүй хүргэж ажиллаж байна.

➤ **Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл Үүнд :**

- Төрсний бүртгэл – 2
- Гэрлэлт цуцлалт - 1
- Нас барсны бүртгэл – 1

➤ **Иргэний цахим үнэмлэх олголт:**

- Иргэний үнэмлэх захиалга ИУБ-31 – Зиргэн
- Иргэний үнэмлэх олголтын бүртгэл – 2 иргэн
- Иргэний үнэмлэхний лавлагаа олголт албан хэрэгцээнд – 9
- Иргэний үнэмлэхний лавлагаа олголт иргэнд – 1

➤ **Лавлагаа гэрчилгээ дахин олголт**

- Гэрлэлт бүртгэлийн лавлагаа албанд -2иргэнд
- Төрсний гэрчилгээ дахин олголт – 0 иргэнд
- Нас барсны лавлагаа иргэнд – 0 иргэнд

гэх мэт иргэний бүртгэлийг холбогдох бичиг баримтыг хүлээн авч хүсэлтийн дагуу шийдвэрлэж ИУБ хаадар маягтуудыг Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэст сар бүрийн 24-нд үнэт цаас, үйл ажиллагааны тайлан мэдээг тогтмол цаг хугацаанд хүргүүлж байна.

Мөн аймаг хот, сум дүүрэг баг хооронд, иргэний үнэмлэх захиалга, иргэний үнэмлэх олголт үрчилэлт, гэрлэлт, шинэ төрсөн, лавлагаа мэдээллийн зэрэг журналуудыг хөтлөж байна.

Судалгаа: Улсын бүртгэлийн хэлтэст хүний нөөцийн судалгааг цаг тухайд нь хүргүүлсэн. Мөн хэлтэсийн civilreg tool, veritech tool программ шинэчилэгдэж шинэчилэн суулгасан байна.

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Төсөл хөтөлбөрүүд зарлагдсантай холбогдуулан зарыг Сүхбаатар аймаг Наран сум, Зар мэдээ мэдээлэл Наран сум группүүдэд 3 удаа байршуулсан мөн дэлгүүрүүдэд зар тавин 5 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Ажил зуучлалаар 3 иргэнийг Lmis программд бүртгээд байна.

Авто засварчин мэргэжлийн сургалтад хамрагдах зар тавин 11 иргэнд мэдээлэл өгөн 4 иргэнийг бүртгэсэн.

Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдтэй холбогдон 906250 төгрөгийг төлүүлсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийх асаргаа шинээр тогтоолгох-1, асаргаа сунгалт хийлгэх-2 иргэний, ОНОТХҮ-ий 1 төслийг хэлэлцсэн. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төсөл сонирхсон 4 иргэнд мэдээлэл өгч ажилласан.

2 дугаар сарын 21-нээс өдрийн үйлчилгээнд 10 ахмадыг хамруулсан. Өдрийн үйлчилгээг албан газруудтай хамтран зохион байгуулсан.

2 дугаар сарын 22-нд өдрийн үйлчилгээнд хамрагдсан ахмадуудад “Ахмад настны тухай хууль, протез, ортопед, тусгай хэрэгсэл, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээний төслийн талаарх мэдээлэл хийсэн. 2 сарын 24 –нд ЭМТ хөдөлгөөн, эмийн зохистой хэрэглээ сэдвээр сургалт хийн хөгжөөнт тэмцээн явуулж 3 хоног бариа, шарлага, бумба үйлчилгээ үзүүлсэн . 3 дугаар сарын 4-нд ЗДТГ хаалтын арга хэмжээ зохион байгуулж ЗДТГ-ын орлогч 2021 оны бүтээн байгуулалтын ажил, 2022 онд хийх бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл өгөн азын сугалаа, АХА тэмцээнийг явуулсан. Азын сугалаа, тэмцээнийг эд зүйлсийг ЗДТГ-ын ажилчид хандив болгон өгсөн.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Орлогын талаар

1. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 26 иргэний 1622,8 мянган төгрөг оруулсан.
2. Эрүүл мэндийн даатгалд 16 иргэний 554,4 мянган төгрөг оруулсан.

Зарлагын талаар

1. 268 иргэнд 134976,8 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна..
2. 3 иргэнд 3000000 сая төгрөгийн оршуулгын тэтгэмж олгосон .

Бусад

- Сайн дурын даатгалд 5 иргэн шинээр хамруулсан.
- Санхүүгийн баримт архивлаж нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн 5 баримт
- 8 иргэний тэтгэвэр шинээр тогтоосон.
- Тэтгэвэрийн нэмэгдэл хийсэн.
- Хувийн хэргийн тооллого хийсэн.
- Жирэмсэн амаржсаны тэтгэмж 1 хянаж НД-н хэлтэст хүргүүлсэн.

Өргөдөл

- Банк солих 3
- Тэтгэвэр тогтоолгох 8
- Оршуулгын тэтгэмж олгох 3
- Жирэмсэн амаржсаны 1
- Нийт 15 өргөдөл шийдвэрлэсэн байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Үндсэн ажил үүргийн талаар

2022 оны 02-р сарын 22-нд 7 иргэний шагналын материал бүрдүүлэн холбогдох дээд газарт хүргүүллээ. Тус шагналд Хөдөө аж ахуйн тэргүүнд-3, Хөдөө аж ахуйн жуух бичиг-1, Аймгийн засаг даргын баярын бичиг-4, аймгийн засаг даргын жуух бичиг-1 хүн тодорхойлолтыг тус тус явууллаа.

2022 оны 02-р сарын 23-нд Малчдын зөвлөгөөнд оролцогчдод зориулсан мал төллөлт , хорогдолын мэдээний дэвтэрийн эх бэлтгэлээ. 02-р сарын 24-нд Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтанд тодорхойлон тодорхойлолтыг холбогдох дээд газарт хүргүүллээ.

“Хөдөөгийн иргэдийг цаг уур амьсгалын өөрчилөлтөд дасан зохицох менежментийг сайжруулах нь” төслийн сургалтад онлайнаар хамрагдаж мэдээлэл авсан. Үүний дагуу шаардлагатай хөдөө аж ахуйн салбарын мэдээллийг хүргүүлж ажилласан.

2020 оны 03-р сарын 02-ны өдөр “Малчдын зөвлөгөөн”-ийг угтан даам, волейбол, буухиа 3 төрлөөр спортын өдөрлөг зохион байгууллаа. Даамны тэмцээнд нийт 22 хүн бүртгүүлэн оролцсоноос шагналт байруудад



2-р багийн малчин Г.Адарсүрэн-1-р байр

1-р багийн малчин С.Бямбадэлгэр -2-р байр

3-р багийн малчин Х.Ням-Очир-3-р байр тус

тус эзэлсэн. Тус тэмцээнийг улсын аварга малчид
ивээн тэтгэж явууллаа.



Волейбол, буухиа тэмцээнд тус бүр 5 баг оролцож багуудын идэвх сайн байлаа.
Тус тэмцээнүүдийг 1,2-р багийн Засаг дарга нар ивээн тэтгэн амжилттай зохион
байгуулсан.



2022 оны 03-р сарын 03-нд Малчдын зөвлөгөөн 2022 арга хэмжээ зохион
байгуулагдаж тус зөвлөгөөнд 187 малчин хамрагдлаа. Зөвлөгөөнд хөдөө аж ахуйн
салбарын өнөөгийн байдал , тулгамдаж буй асуудал цаашидын чиг хандлагын талаар

болон онцгой нөхцөлд хэрхэн ажиллах зааварчилгаа малын эрүүл мэндийн талаар мэдээлэл сургалт өгч малчдын санал хүсэлтийг сонсож ажилласан. Зөвлөгөөнд аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлэг, Сумын ИТХ-ын ажлын алба хамран ажилласан.

Мөн хөдөө аж ахуйн салбарыг хүүхэд багачуудад сурталчилан таниулах зорилгоор “Наран хурд” сумын үе үеийн хурдан хүлгүүдийн зургийг зурах уралдааныг МСУХ-той хамтран зохион байгуулсан.



Зөвлөгөөний үеэр:

-Хөдөө тэргүүний ажилтан тэмдэгээр:

1-р багийн малчин , малын бага эмч Д.Батбаатар

1-р багийн иргэн ахмад ажилтан Ч.Лувсанмаа

1-р багийн малчин А.Жагваралжав нар

-Аймгийн засаг даргын баярын бичгээр:

1-р багийн малчин Д.Гэрэлмаа

2-р багийн малчин Г.Чулуунцэцэг

2-р багийн малчин Г.Бат-Эрдэнэ

2-р багийн малчин Д.Ганзориг

2-р багийн малчин Д.Наранцэцэг

-Аймгийн засаг даргын жуух бичгээр:

3-р багийн малчин С.Оюунчимэг

2-р багийн малчин Л.Даваа

2-р багийн малчин Б.Энхчулуун

-Сумын засаг даргын баярын бичгээр:

2-р багийн малчин Б.Алтансүвд

2-р багийн малчин Ц.Ариунаа

1- р багийн малчин С.Мөнх-Эрдэнэ нар тус тус шагнагдлаа.



Зөвлөгөөний үр дүнд малчид өөрийн эрхлэж буй салбарын мэдээлэл цаашид үйл ажиллагаагаа сайжруулах чиглэлийг авснаас гадна худаг уст цэгийн хангамж хүртээмжийг сайжруулах талаар саналаа холбогдох албан тушаалтнуудад илэрхийлсэн.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Эрчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа аяны хүрээнд нээлт хийж 32 насанд хүрэгчид, 43 хүүхэд хамрагдсан.

Мөн эх орончдын өдөрт зориулсан цэнгүүн зохиосон.

Ардын авьяастан Э.Бөхчулуун, Амарбаатар нарын

“Амин үргэлжлэл” тоглолтын цэнгүүнийг зохион байгуулсан.



Март 8-ныг угтан цэцэрлэгийн хүүхдийн “Миний ээж хөөрхөн” ээжтэйгээ дуулах дууны тэмцээн

Олон Улсын эмэгтэйчүүдийн баяр “Баярын хурал”

Олон Улсын эмэгтэйчүүдийн баяр мартын 8-ныг тохиолдуулан “Ээждээ захидал бичээрэй” захидлын уралдааныг насанд хүрэгчид, хүүхэд гэсэн ангиллаар явуулж нийт 24 бүтээл ирж шалгарсан захидлыг ээжид нь баярын хурлын үеэр гардуулж шагнаж урамшуулсан.

Л.Соронзонболд, Х.Хатантөмөр нарын “Нутгийн түмэндээ” тоглолтыг бэлтгэн хүргэсэн.

ЕБС-ийн багш ажилчид сурагчдын хамтарсан “Ээжийн бүүвэйтэй хорвоо” тоглолтын бэлтгэл ажлыг хангасан. Үдшийн цэнгүүн зохиосон.

Цэргийн баярыг угтан явуулсан хөзөрийн бооцоот тэмцээн. Мөн Цэрэг эрсийн дурсамж цахим фото зургийн уралдааныг явуулж нийт 33 оролцогч оролцсон.



Шагайн харвааны тэмцээнийг шагайн холбоотой хамтран зохион явуулсан.

Аймгийн Нийтийн номын сангаас “Номын санчдыг чадавхжуулах нь сэдэвт ээлжит сургалтад хамрагдаж мөн дэлхийн яруу найргийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор “Уран үгс эгшиг дууны яруу үдэш” арга хэмжээнд Ш.Санчирмааг оролцуулсан. Энэ үеэр номын санчдын спортыг 6 дугаар наадамд оролцох оролцогчдыг шалгаруулж 5 төрөлт тэмцээнийг зохион байгуулахад шатар, гар бөмбөг, сагсан бөмбөгийн төрөлд оролцож багаараа 2 дугаар байр эзэллээ.



Орон нутаг судлах танхимыг тохижуулж үзмэрүүдийг нэмэгдүүлэн ажиллаж байна.



БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Сүхбаатар аймгийн нийтийн номын сан болон сумын номын сангаас зохион байгуулагдаж буй” Судар эгшиглэн” тэмцээнд байгуулага хамт олноороо “ Номын садан” клубээрээ дамжуулан багш нар оролцож байна. мөн суралцагчид хуваарийн дагуу сард 1 удаа номоо уншиж тэмдэглэл хөтлөн цахимд оруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

2022.03.10-нд Олон улсын логик ПАЗЗЛЫН уралдааны анхан шатны шалгаруулалт амжилттай зохион байгуулагдаж аймгийн уралдаанд оролцох суралцагчдыг

шалгаруулан шагналыг гардууллаа. Бага ангийн 77, дунд ангийн 45 нийт 122 суралцагч хамрагдсан өргөн цар хүрээтэй, өндөр ач холбогдолтой уралдаан болж өндөрлөлөө. Мөн 1,2-р байр эзэлсэн суралцагчид 3-р сарын 26-нд СБ-аймагт болох сэтгэх чадварын тэмцээнд оролцох бэлтгэл ажлаа хангаж байна.



3-р сарын 08-ны өдөр нийт байгууллагын багш,ажилчид, сурагчдын хамтарсан “Ээжийн бүүвэйтэй хорвоо” тоглолтыг зохион байгууллаа.



Өсвөрийн сагсан бөмбөгийн ААШТ-д Биеийн тамирын багш Л. Ариунболдын бэлтгэсэн баг тамирчид аваргын алтан медаль хүртлээ.



ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Долоодой, “Хөгжмийн-Хэмнэл” дугуйлангийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан 7 хоногт 1 удаа хичээллэж байна.

3-5 настай хүүхдийн дунд “Миний ээж хөөрхөн” хүүхдийн дууны тэмцээнийг ээжтэйгээ, эмээтэйгээ, эгчтэйгээ хамтран дуулах тэмцээнийг зохион байгуулж нийт 31 хүүхэд оролцсон.

Байгууллагынхаа багш ажилчдынхаа “Цэгээр наадья-100”-ийн уралдаанд зурлага бичвэр болон бүтээлээр оролцож үзэсгэлэнгийн бэлтгэл ажлыг хангаж байна. Одоогоор 3-5 настай 86 бүтээл, багш ажилчдын 10 бүтээл ирээд байна.

Энэ 3 сарыг бүлгийн хүүхдүүдийн дунд гар угаах дадал хэвшлийн сар болгон зарлаж түүний дагуу эцэг эх, асран хамгаалагчдад гар угаах дараалал, зөвлөмж, аргачлал зэргийг хүргүүлэн гэрт гар угаах дадлыг давхар хэвшүүлж видео бичлэгээр баталгаажуулан ажиллаж байна. Одоогоор 15 хүүхэд бичлэг ирүүлээд байна.

“Миний гэр бүл-аюулгүй орчин” гар зургийн уралдаанд нийт 21 хүүхэд оролцож, өөрийн эргэн тойрон байранд байгаа эрсдлийг өөрийн үзэл бодлоор зураг болгон зурсан. Бүтээлийг бүлгийн багш нараар дүгнүүлэхэд 1-р байранд П.Аминзаяа, 2-р байранд М.Баярхишиг, 3-р байранд Б.Нандинзаяа, тусгай байранд Ц.Амирлангуа нар шалгарсан.

Хоёр : Мэдлэг боловсролоо дээшлүүлсэн байдал

Судар-Эгшиглэн 2022 төслийн хүрээнд багш ажилчид сар бүрийн 15 ны өдөр Номын нөхөр арга хэмжээг зохион байгуулж тухайн сард уншсан номыг талаарх мэдээллийг бусдадаа түгээн дэлгэрүүлэлт хийсэн.

Сум орон нутгаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн-2022” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнд 15

албан хаагчид хамрагдаж байгууллагынхаа 2021 оны хийсэн онцлог ажил болон 2022 онд хийх бүтээн байгуулалтын талаарх мэдээллийг хүргэсэн. Мөн энэ үеэр 2021 оны шилдэг байгууллага, ХАБЭА үйл ажиллагаагаар шилдэг байгууллага хамт олон, БШУЯ-ны шагналаар-1 багш, сумын хүндэт өргөмжлөлөөр -1 ажилтан нар шагнаж урамшууллаа.

Аймгийн хэмжээнд “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” аяны нээлтийн үйл ажиллагаа болон сургалтад 3 эрэгтэй албан хаагч, 1 эмэгтэй албан хаагчид хамрагдсан. Мөн энэ аяны хүрээнд байгууллага дээрээ “Цай юу кофе юу” ажлын ярилцагыг эрэгтэй албан хаагчдын дунд зохион байгуулж санал бодлыг сонсож дархлаажуулан хамтран ажилласан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

Үндсэн үзүүлэлтүүд:

Нийт үзлэг-456

Урьдчилан сэргийлэх-159

Амбулаторт-97

Артерийн гипертензин эрт илрүүлэг-40

Чихрийн шижин эрт илрүүлэг-50

Жирэмсний хяналтад байгаа-10

Шинээр хамрагдсан-1

Жинэлсэн хүүхдийн тоо-22

Эмнэлэгт хэвтсэн-23

Дусал тариа-245

Судас тариа-210

Булчин тариа-85

Арьсан доорх тариа-22

Уян зүү-25

Катетр-2

Боолт-4

Хүчилтөрөгч-3

Сэргээн засах: Нил улаан туяа-54

Хэсэгчилсэн зөөлөн бариа-8

Бумба-8

Утлага-16


Холын дуудлага-18

Төвийн дуудлага-70

“АРХИ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХОР УРШИГ”-ЫН ТАЛААР 14 ХОНОГИЙН АЯНЫ ДАГУУ ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

“АРХИ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХОР УРШИГ”-ЫН ТАЛААР 14 ХОНОГИЙН АЯНЫ төлөвлөгөөг гаргаж даргаар батлуулсан.

1. “АРХИ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХОР УРШИГ”-ЫН талаар видео бичлэг хийж “НАРАН ЭМТ” хаягт байршуулсан. Тандалт 210 гаруй
2. “НАРАН ЭМТ” пэйж хуудсаар 11 төрлийн зөвлөгөө зөвлөмж хүргэсэн тандалт-180 гаруй



СҮХБААТАР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД “ЭРЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” 2 САРЫН 18-наас 3 САРЫН 18 ХҮРТЭЛХ 1 САРЫН АЯН ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА:

“Эрчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” аяны төлөвлөгөөг гаргаж даргаар батлуулж төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгэлээ“Эрчүүдийн эрүүл мэндийн төлөө

ЭРЧТЭЙНХҮДИЙН –ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ГАРГАЖ ДАРГААР БАТЛУУЛЖ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ				
№	АНГИ	ЦАГ	ХУГАЦАА	ҮЗЛЭГ ХИЙЖ ЭМН
1	Бага бүлэг	10.00	3 сарын 9	Их эмч Б.Гантуяа
2	Дунд бүлэг	11.00	3 сарын 9	Их эмч Б.Гантуяа
3	Ахлах бүлэг	10.00	3 сарын 9	Эх баригч бага эмч Ө.Мөнхтүвшин
4	Бэлтгэл бүлэг	11.00	3 сарын 9	Эх баригч бага эмч Ө.Мөнхтүвшин

ЭРЧТЭЙНХҮДИЙН –ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” АЯНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ ГАРГАЖ ДАРГААР БАТЛУУЛЖ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ				
№	АНГИ	ЦАГ	ХУГАЦАА	ҮЗЛЭГ ХИЙЖ ЭМН
1	Бага бүлэг	10.00	3 сарын 9	Их эмч Б.Гантуяа
2	Дунд бүлэг	11.00	3 сарын 9	Их эмч Б.Гантуяа
3	Ахлах бүлэг	10.00	3 сарын 9	Эх баригч бага эмч Ө.Мөнхтүвшин
4	Бэлтгэл бүлэг	11.00	3 сарын 9	Эх баригч бага эмч Ө.Мөнхтүвшин

хамтдаа” аяны хүрээнд

Албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэд, ЕБС, СӨБ-н урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний хуваарийг гаргаж хуваарийн дагуу хийгдлээ.

Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээны талаар

2022 оны 3 сарын 5 нд Төсөвт 5 байгууллагын нийт 78 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг болон элэгний В,С вирусын шинжилгээ, сахар, хеликобактерийн шинжилгээг авсан үүнээс В вирус эр-2 эм-2, С вирус эр-5, эм-3 эерэг гарч, эерэг гарсан ажилчдыг 2 дахь шатны эмнэлэгт үзүүлэхээр чиглүүлж, зөвөлгөө өглөө, сөрөг гарсан эр-16, эм-24 нийт-40 буюу 78/40/51,2% албан хаагчийг гепатит В-ын вакцинжуулалтад хамрууллаа.

2022 оны 3 сарын 7-18ныг хүртэл Ард иргэд аж ахуйн нэгжийн иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг болон элэгний В,С вирусын шинжилгээ, сахар, хеликобактерийн шинжилгээг авсан үүнээс В вирус- эр-2, эм-2, С вирус- эр-2 эм-0 эерэг гарч, эерэг гарсан иргэдийг 2 дахь шатны эмнэлэгт үзүүлэхээр чиглүүлж, зөвлөж сөрөг гарсан иргэдийг гепатит В-ын вакцинжуулалтад эр-18, эм-16, нийт-34 хүнийг хамруулан ажилласан.

2022 оны 2сарын 26, 27ны өдрүүдэд Хилийн 5,6-р заставын нийт-27 албан хаагч, цэргүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, ковид19 халдвараас сэргийлэх дархлаа сэргээх 3,4-р тунгийн вакцинжуулалтыг хийсэн.



2022 оны 2 сарын 28-3.2-ныг хүртэл ЕБС-н 1-9-р ангийн 249 сурагчид, үүнээс эр-119, эм-130 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж эрэгтэй хүүхдийн шүд - 119/66/55,4% , эмэгтэй шүдний өвчлөл-130/55/42,3%-г эзэлж байна.



2022 оны 3 сарын 09-нд СӨБ-ийн 57 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийгдсэн. Үүнээс шүдний өвчлөл 60%-г ТТТӨ-30%-г эзэлж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.



Аяны хүрээнд нийт 1677/453/27,1% иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажилласан байна.

Наран суманд 18-с дээш насны амьдарч эрэгтэйчүүдийн судалгааг гаргасан. 1677/456-эрэгтэйчүүд буюу хүн амын 27,1%-г эзэлж байна.

Энэхүү аяны хүрээнд СБ аймаг дахь “Түмэн-Үйлст” компантай хамтран В,С-400ш, сахар-400ш оношлуурыг 1сая,600мянган төгрөгөөр авчирж үзлэг шинжилгээг хийж байна.

Сургалт сурталчилгааны чиглэлээр

- 2022 оны 3 сарын 01 “Эрчүүдийн эрүүл мэндий
- Он төлөө хамтдаа аян” нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж АБ, АЖАН, иргэд нийт-74 иргэн хамрагдсан.Нээлтийн үеээр:
 - “Эртэч залуус” өглөөний цай хөтөлбөр
 - “Элгээ хайрла”
 - “Архи тамхины хор уршиг”-ын талаарх сургалт орж, эрчүүдэд тулгамдаж буй асуудлын талаар нээлттэй ярилцлага хийсэн



6-9-р ангийн 45 эрэгтэй сурагчдын дунд “Өсвөр насны эрүүл мэнд “ сэдэвт сургалтыг орж, 4 багт хувааж хүүхдийн насны онцлогт тохируулан сэдэв өгч сэдвийн дагуу багаараа ярилцаж үгээр , богино хэмжээний хошин үзүүлбэрээр, зургаар бусаддаа танилцуулсан. Сургалтыг бататган “АХА” тэмцээн зохион байгуулж 1,2,3-р байрыг шалгаруулж, 88000 мянган төгрөгний дархлаа дэмжих витаминжуулалт хийгдсэн.



2022оны 2 сарын 26, 27-ны өдрүүдэд Хилийн 5,6-р заставын нийт-27 албан хаагчдад “Архи тамхины хор уршиг”-ын талаарх сургалт орж “Архи тамхи бидний сонголт биш” чөллэнжид нэгдүүлэн 27н албан хаагчдад дархлаа сэргээх 865500 төгрөгний витаминжуулалтаар дэмжин ажиллалаа.



Зорилтот бүлгийн 18 иргэнд

“Элгээ хайрла”

“Архи тамхины хор уршиг”-ын талаарх сургалтыг орж, эрт илрүүлэг үзлэгт хамруулж, 8 иргэнийг гепатит В вакцинжуулалтад хамрууллаа.

Сумын 18-с дээш насны эрэгтэйчүүдийн дунд цагийг үр бүтээлтэй, бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор Сагсан бөмбөгийн тэмцээнд зохион байгуулж нийт-7 баг оролцож 1,2,3-р байрыг шалгаруулж, мөнгөн шагнал, медаль, дархлаа дэмжих нийт-525000 төгрөгний бүтээгдэхүүнээр хангалаа.





“Архи тамхи бидний сонголт биш чөллэнжийг 1 сарын аяны хүрээнд зохион байгуулж нийт-65 иргэн чөллэнжид хамрагдсан.



Цахим мэдээлэл Наран ЭМТ пэйж хуудсаар 14 төрлийн зөвлөмж хүргэсэн. Хандалтын тоо-240 гаруй. Томуу томуу төст өвчин ихсэж буйтай холбогдуулан Эмт-өөр үйлчлүүлж буй иргэдэд ТТТӨ-с урьдчилан сэргийлэх 50ш зөвлөмжийг тараан ажилласан. Цахим хаягаар өдөр бүр мэдээ мэдээлэл хүргэж байна.



Хэвтэн эмчлүүлсэн эхчүүдэд хүүхдийн хооллолтын сургалт , хийж зөвлөгөө өгсөн.



Бусад

Төрсөн эх болон нярайг гэрийн эргэлтийг 7 хоногт 1 удаа хийж зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд зөвлөгөө зөвлөмж авч ажиллаж байна.



**ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.ЛЭГЖИЙМАА**